

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
2015 ОНЫ ЭХНИЙ 12 САРЫН ДҮНГИЙН
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**



МӨНГӨ, БАНК, ДААТГАЛ

2015 оны эхний 12 сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 8314.9 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 571.8 сая төгрөгөөр буюу 9,3 хувиар өссөн байна. 2015 оны эхний 12 сарын байдлаар нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Жаргалант, Баянлиг, Баянбулаг, Баацагаан, Бууцагаан, Заг сумууд биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: НӨАТатвар 89,5 сая төгрөг, ҮХЭХ-н татвар 0,7 сая төгрөг, газрын төлбөр 13,3 сая төгрөг, ИОТТХ 36,6 сая төгрөг, патент 2,1 сая төгрөг, хог хаягдлын хураамж 18,1 сая төгрөг, нохойн татвар 1,3 сая төгрөг, бууны татвар 0,5 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 21,4 сая төгрөг, түгээмэл тархацтай АМАТ 22,9 сая төгрөг, ус ашигласны төлбөр 83,7 сая төгрөг, ҮХЭХ борлуулсны 16,1 сая төгрөгөөр тус тус тасарч бусад нэр төрөлд биелэлээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 2,3 хувь, нэмүү өртгийн албан татвар 6.7 хувь, ЦХТА орлого 53,3 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 4.0 хувь, хүү торгууль 7,0 хувь бусад төлбөр хураамж 26,7 хувийг эзэлж байна.

2015 оны 12 дүгээр сарын эцэст иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 48766,2 сая төгрөг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 114456,3 сая төгрөгт хүрчээ. Чанаргүй зээл 1396,3 сая төгрөгт хүрсэн нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1,2 хувийг эзэлж байна.



ЭРҮҮЛ МЭНД

2015 оны эхний 12 сарын байдлаар аймгийн хэмжээнд 2125 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 49 төрөлтөөр буурсан байна. Нийт төрсөн эхийн 84,8 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын эмнэлэгт 3.2 хувь, 11,9 хувь нь сумын эмнэлэгт төрж, Бууцагаан, Баянлиг, Баянцагаан, Гурванбулаг сум, Оточмандал, Наранмандал, Оточномгон өрхийн эрүүл мэндийн төвд гэрийн төрөлтийн тохиолдол бүртгэгдэж, нийт төрөлтөд гэрийн төрөлтийн эзлэх хувь 0.43 болж өссөн байна.

Нийт амьд төрсөн 2133 хүүхдийн 24 нь ихэрлэж, 3,6 хувь нь дутуу төрж, 99,8 хувь нь 1 цагийн дотор хөхөө амласан байна. Нялхасын эндэгдэл 1000 амьд төрөлтөд эхний 12 сарын байдлаар 14,1 байна.

Эхний 12 сарын байдлаар архаг болон цочмог халдварт өвчний гаралтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад салхин цэцэг 105, тэмбүү 73, арьсны мөөгөнцөр 10, бруцеллөз 3, сүрьеэ 9, суулгалт халдвар 11, трихоминиаз 12, гар

хөл амны өвчин 5, тохиолдлоор өссөн бол цусан суулга 1, гахайн хавдар 3 тохиолдлоор тус тус буурсан байна.

Аймгийн хэмжээнд эхний 12 сарын байдлаар нас баралтын 477 тохиолдол бүртгэгдсэний 26,6 хувь нь эмнэлэгт нас барснаас 31,4 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс буурсан байна./2014 онд 35,2/

Түргэн тусламжийн дуудлага өнгөрсөн оны эхний 12 сард 15332 байсан бол энэ оны эхний 12 сарын байдлаар 14519 болж 813 дуудлага буюу 9,4 хувиар буурсан байна.



АЖ ҮЙЛДВЭР

2015 оны эхний 12 сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 4971093 мянган төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 20491 мянган төгрөгөөр буюу 9,9 хувиар буурчээ.

Эхний 12 сарын байдлаар аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг авч үзэхэд урьд оны мөн үеэс нарийн боов 19.7 тн-оор, талх 38.9 тн-оор, хоормог 5,1 мян.литр, түгээсэн цэвэр ус 7 мян.м3-ээр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт өссөн дүнгээр /мян.төг/

	Арванхоёрдугаар сар		
	2014	2015	2015.12/2014.12
Нийт борлуулалт	4991584	4971093	99,6

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /өссөн дүнгээр/

Бүтээгдэхүүний нэрс	хэмжих нэгж	Арванхоёрдугаар сар		
		2014	2015	2015.12/2014.12
Тараг	Мян.л	3.6	4.9	136.1
Хоормог	Мян.л	3.6	8.7	241.7
Нарийн боов	тн	60.5	80.2	132.6
Талх	тн	82.5	121.4	147.1
Түгээсэн цэвэр ус	Мян.м3	270.7	277.1	102.4



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд 3771867 толгой мал тоолуулсны дотор тэмээ 44496, адуу 141338, үхэр 189019, хонь 1082565, ямаа 2314449 толгой тоологдож, нийт малын тоо өнгөрсөн оныхоос 8,8 хувь буюу 306,0 мянгаар өссөн.

Баацагаан, Баянбулаг, Баянговь, Баянлиг, Баян-Өндөр, Баян-Овоо, Баянцагаан, Богд, Бөмбөгөр, Бууцагаан, Гурванбулаг, Жаргалант, Жинст, Өлзийт, Хүрээмарал, Шинэжинст зэрэг 16 сум малаа 5 төрөл дээр нь өсгөжээ.



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

2015 оны эхний 12 сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 21356,8 сая төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 59,1 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 26,4 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 400,9 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 45,5 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 948,9 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 239,0 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 59,1 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 1776,6 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 236,6 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээний эмийн зардалд 3543,2 сая төгрөг, рашаан сувиллын зардалд 660,0 сая төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 416,1 сая төгрөг тус тус олгожээ.

Нийгмийн халамжийн сангаас 2015 онд 1857 хүнд 2997,6 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр олгосон байна. 2015 онд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 4214 иргэнд 2474,3 сая төгрөгийн хөнгөлөлт, мөнгөн тусламж, 1124 ахмадад 539,8 сая төгрөгийн нэг удаагийн хөнгөлөлт тусламж, хөгжлийн бэрхшээлтэй 738 иргэнд 124,7 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж олгожээ.



ГЭМТ ХЭРЭГ

2015 оны эхний 12 сард аймгийн хэмжээнд нийт 360 хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 70 нэгжээр буюу 16,3 хувиар буурсан. Хэргийн илрүүлэлт 71.2 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1,8 пунктээр буурсан. Хэргийн гаралт 11 суманд буурч, 4 суманд өсөж, 4 суманд ижил түвшинд байна. Гэмт хэрэгт 401 хүн холбогдон шалгагдсан ба үүнээс 14-17 насны 33, 18-с дээш насны 368 хүн байна. Гэмт хэргийн улмаас 386 иргэн хохирч 12 хүн нас барж, 180 хүн гэмтсэн байна. 496,2 сая төгрөгийн хохирол учирснаас 344,5 сая төгрөгийг төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 69,4 хувьтай байна.

Хүнийг санаатай алах гэмт хэрэг 5 нэгжээр буюу 83,3 хувь, бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэрэг 3 нэгжээр буюу 2,2 хувь, хүчин 5 нэгжээр буюу 41,6 хувь, өмчийн хулгай 4 нэгжээр буюу 3,2 хувь, иргэдийн өмчийн хулгай 10 нэгжээр буюу 11,6 хувь, танхай 6 нэгжээр буюу 31,5 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 26 нэгжээр буюу 54,1 хувь, бусад гэмт хэрэг 21 нэгжээр буюу 29,1 хувь, насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэрэг 17 нэгжээр буюу 34 хувь тус тус буурсан байна.

Харин дээрэм 4 нэгжээр буюу 1,3 дахин, залилан 1 нэгжээр буюу 25 хувь, малын хулгай, булаалтын гэмт хэргүүд өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд байна.



ҮНЭ ТАРИФ

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКС, 12 дугаар сард, суурь онтой харьцуулснаар

хувь

Ерөнхий индекс	Хүнсний бараа, ундаа, ус	Согтууруулах ундаа, тамхи	Хувцас, бөс бараа, гутал	Орон сууц, ус, цахилгаан, түлш	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	Тээвэр	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	Боловсролын үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар, дотуур байр	Бусад бараа, үйлчилгээ
174.4	147.9	229.4	234.4	139.5	258.4	124.1	138.1	92.7	81.8	240.0	198.6	150.9

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКС, 12 дугаар сард, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

хувь

Ерөнхий индекс	Хүнсний бараа, ундаа, ус	Согтууруулах ундаа, тамхи	Хувцас, бөс бараа, гутал	Орон сууц, ус, цахилгаан, түлш	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	Тээвэр	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	Боловсролын үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар, дотуур байр	Бусад бараа, үйлчилгээ
106.4	96.6	108.8	113.3	103.6	110.9	106.0	107.1	97.5	100.0	104.3	100.0	111.0

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКС, 12 дугаар сард, өмнөх оны жилийн эцэстэй харьцуулснаар

хувь

Ерөнхий индекс	Хүнсний бараа, ундаа, ус	Согтууруулах ундаа, тамхи	Хувцас, бөс бараа, гутал	Орон сууц, ус, цахилгаан, түлш	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	Тээвэр	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	Боловсролын үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар, дотуур байр	Бусад бараа, үйлчилгээ
106.4	96.6	108.8	113.3	103.6	110.9	106.0	107.1	97.5	100.0	104.3	100.0	111.0

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКС, 12 дугаар сард, өмнөх сартай харьцуулснаар

хувь

Ерөнхий индекс	Хүнсний бараа, ундаа, ус	Согтууруулах ундаа, тамхи	Хувцас, бөс бараа, гутал	Орон сууц, ус, цахилгаан, түлш	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	Тээвэр	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	Боловсролын үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар, дотуур байр	Бусад бараа, үйлчилгээ
99.9	99.2	100.0	100.7	97.9	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.1

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС